



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 02 сарын 21 өдөр

Дугаар 11

Номгон

Давхар бүртгэлтэй үл хөдлөх  
хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 62 дугаар зүйлийн 62.2, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3а, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит төсвийн байгууллага болон төсөвт үйлдвэрийн газар эд хөрөнгө олж авах, бүртгэх, дуудлагаар худалдах, шилжүүлэх, актлах журам”-ын 1.6 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Баянлиг сумын Цагдаагийн кабон нь 2010 онд ашиглалтад орсон Баянлиг сумын Засаг даргын Тамгын газар 2010 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр 52 600 000 төгрөгөөр Галуут сумын Засаг даргын Тамгын газар 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр 78 000 000 төгрөгөөр тус тус барилга байгууламж дансанд бүртгэсэн, мөн аймгийн Цагдаагийн газар 2010 оны 12 дугаар сарын 31-ний өдөр 45 808 617 төгрөгөөр Баянлиг цагдаагийн кобан нэртэй, 2015 оны 12 дугаар сарын 28-ны өдөр 76797753 төгрөгөөр Галуут сум кобан нэртэйгээр орлого авч давхар бүртгэл үүссэн тул Баянлиг, Галуут сумдын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгийн бүртгэлээс хассугай.

2. Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Ч.Мөнхцэцэг/-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1 Давхар бүртгэлтэй хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.2 Тогтоолын хэрэгжилтийг 2018 оны 2 дугаар улиралд багтаан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албанд ирүүлэх.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д даалгасугай.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР

D:/2018/Alban bichig/TH togtool-2018

011.173